



**МОНГОЛ УЛСЫН  
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН  
ИХ ЧУУЛГАНЫ ТОГТООЛ**

1997 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн  
гишүүнийг сонгох журам”-ын тухай

Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хууль, ШУА-ийн дүрмийг үндэслэн Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Их чуулганаас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн гишүүнийг сонгох журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЧАДРАА

ЭРДЭМТЭН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Т.ГАЛБААТАР

## **МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ГИШҮҮН СОНГОХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл.**

1. Монгол Улсын Шинжлэх ухааны Академи /цаашид "Академи" гэх/-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгоход энэхүү журмыг мөрдөнө.

2. Энэ журам нь Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.5, дүрмийн 3 дугаар зүйлийн заалтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

3. ШУА-ийн гишүүнээр шинжлэх ухааныг хөгжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулсан, эрдэм судлалын ажлын үр дүнгээрээ өөрийн орны болон олон улсын түвшинд /гадаад орны академийн гишүүн гэх мэт/ үнэлэгдсэн шинжлэх ухааны докторын зэрэгтэй, шинжлэх ухааны ёс зүйг хүндэтгэдэг, нэр хүнд бүхий Монгол улсын иргэнийг сонгоно.

4. Дэлхийн болон монголын шинжлэх ухааны хөгжилд гарамгай хувь нэмэр оруулсан гадаад орны нэрт эрдэмтдийг ШУА-ийн гадаад гишүүнээр сонгоно.

4'. Шинжлэх ухаан-технологийн тэргүүлэх чиглэлээр судалгааны үр дүн нь өөрийн орны болон олон улсын түвшинд үнэлэгдсэн, эрдэм шинжилгээний байгууллага, их сургуульд ажилладаг, шинжлэх ухааны болон боловсролын докторын зэрэгтэй, 45 хүртэлх насны нэр хүнд бүхий эрдэмтнийг квотоор Шинжлэх ухааны Академийн гишүүнээр сонгож болно. (Монгол улсын Шинжлэх ухааны Академийн Их чуулганы 2011 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулав.)

### **Хоёр. Нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг шалгаруулах**

5. ШУА-ийн гишүүнийг сонгох шинжлэх ухааны салбар, чиглэл, тоог Академийн гишүүний сонгууль болохоос 2 сарын өмнө ШУА-ийн Тэргүүлэгчид нийтэд зарлана.

ШУА-ийн гишүүнийг сонгох шинжлэх ухааны салбар, чиглэл, тоог Академийн Бага чуулганаар анхлан хэлэлцэнэ.

5'. ШУА-ийн Тэргүүлэгчид академийн гишүүнийг сонгох шинжлэх ухааны салбар, чиглэл, тоог тогтоохдоо квотын гишүүн 30 хүртэл хувь байх зарчмыг баримтална. (Монгол улсын Шинжлэх ухааны Академийн Их чуулганы 2011 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулав.)

6. ШУА-ийн гишүүнд эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, корпораци, их сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаас нэр дэвшүүлнэ.

Бага чуулганы гишүүн ШУА-ийн гишүүнд шууд нэр дэвших эрх эдэлнэ.

7. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн нууц санал хураалтаар ердийн олонхийн /50-аас дээш хувь/ санал авсан эрдэмтний нэрийг ШУА-ийн гишүүнд дэвшүүлнэ.

7'. Энэхүү журмын 4'-т заасан эрдэмтнийг холбогдох чиглэлийн 3-аас доошгүй академич хамтран Шинжлэх ухааны Академийн гишүүнд нэр дэвшүүлэхээр салбарын бага

чуулганд оруулна. (Монгол улсын Шинжлэх ухааны Академийн Их чуулганы 2011 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулав.)

8. ШУА-ийн гишүүнээр сонгуулахаар нэр дэвшсэн эрдэмтдийн холбогдох материал /бүтээлийн жагсаалт, анкет, эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэр/-ийг тэдний нэрийг дэвшүүлсэн байгууллагууд зарлал нийтэгдсэнээс хойш 20 хоногийн дотор ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт ирүүлнэ.

Нэр дэвшигчийн материалын ШУА-ийн Тэргүүлэгчийн газар нягтлан үзэж 7 хоногийн дотор үзэж 7 хоногийн дотор холбогдох салбарын Бага чуулганд шилжүүлэн өгнө.

9. Бага чуулган ШУА-ийн Тэргүүлэгчдээс зарласан шинжлэх ухааны чиглэл, тоонд гишүүдийн нууц санал хураалтаар, ердийн олонхийн санал ирүүлсэн нэр дэвшигчдээс нэг орон тоон дээр нэг хүнийг шалгаруулна.

10. ШУА-ийн гишүүнд академийн бүтцийн салбар академи болон Бага чуулганаас дэвшүүлсэн эрдэмтний нэрийг сонгууль болохоос 15-аас доошгүй хоногийн өмнө өдөр тутмын хэвлэлд нийтэлнэ. (Монгол улсын Шинжлэх ухааны Академийн Их чуулганы 2011 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулав.)

11. ШУА-ийн гишүүнд нэр дэвшсэн эрдэмтдийн бүтээлд үнэлэлт өгөх ажлын хэсгийг ШУА-ийн тэргүүлэгчид томилон ажиллуулна.

### **Гурав. Сонгууль явуулах**

12. ШУА-ийн гишүүнийг сонгох асуудлыг Их чуулганаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

13. Их чуулган нэр дэвшсэн эрдэмтдийн бүтээлийн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хүн нэг бүрээр сонсож, хэлэл цэн нэрсийн жагсаалтад үлдээх эсэх талаар Академийн гишүүд саналаа хэлнэ. Нэрсийн жагсаалтад үлдээх эсэхийг академийн гишүүдийн ил санал хураалтаар шийдвэрлэнэ.

14. ШУА-ийнгадаад гишүүнээрсонгох саналыгШУА-ийн Ерөнхийлөгчийн өргөн барьснаар Их чуулган хэлэлцэж шийдвэрлэнэ.

15. ШУА-ийн гишүүнийг нууц, гадаад гишүүнийг ил санал хураалтаар сонгоно. Их чуулганд оролцсон гишүүдийн дөрөвний гурвын санал авсан тохиолдолд ШУА-ийн гишүүн, ШУА-ийн гадаад гишүүнээр сонгогдсонд тооцно.

16. Тооллогын комиссыг 3-5 хүний бүрэлдэхүүнтэй сонгож ажиллуулна.

17. Тооллогын комиссын тогтоолыг Их чуулган батална.

18. ШУА-ийн гишүүнээр сонгогдсон эрдэмтэнд ШУА-ийн гишүүний жуух, тэмдэг олгоно.

19. Шинээр сонгогдсон гишүүдийн нэрийг Төрийн төв хэвлэлд нийтлэнэ.